



ХЭЛНИЙ ТУХАЙ ЖУРАМ

Боловсруулсан: 2018 оны 2 сар

Шинэчилсэн: 2019 оны 6 сар

Шинэчлэн найруулсан: 2021 оны 6 сар

Дахин хянах: 2023 оны 6 сар

Хэрэгжих хүчинтэй хугацаа: 2021-2023 он

Шинэ Үе сургууль

2021

Агуулга

Агуулга	1
ЕРӨНХИЙ ЗҮЙЛ	2
СУДЛАХ ХЭЛ	3
Төрөлх хэл:	3
Монгол хэл:	3
Англи хэл:	4
Орос хэл:	4
Хятад хэл:	5
Хэл соёлыг сурталчлах:	5
ХЭЛ ЗААХ БОЛОН СУРАХ АРГА ЗҮЙ	5
ДЭМЖЛЭГ	5
Багшийн зүгээс үзүүлэх дэмжлэг:	5
Сургуулиас үзүүлэх дэмжлэг:	6
Багш нарт үзүүлэх дэмжлэг:	6
ЖУРМЫГ ХЯНАН ӨӨРЧЛӨХ ЯВЦ	7
Ашигласан материалын жагсаалт	8

ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

Шинэ Үе сургууль (цаашид сургууль гэх) нь монгол, англи гэсэн хос хэлээр сургалт явуулдаг бөгөөд энэхүү хэлний журам нь суралцагчид дээрх хоёр хэлээр сургалтын хөтөлбөрийг бүрэн эзэмших, бусадтай чөлөөтэй харилцах, өөрийгөө бүрэн илэрхийлэхэд нь дэмжлэг үзүүлэхэд оршино.

Тус журам нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, Монгол хэлний тухай хууль, Боловсролын тухай багц хууль, Олон улсын бакалавриатын болон Кембриджийн хөтөлбөрийн хэлний бодлогыг удирдлага болгов. Үүнд:

- Сургуулийн бүх мэргэжлийн багш нар өөрсдийгөө хэлний багш гэж үзнэ¹.
- Сургууль нь хэлний сургалт, тухайлбал төрөлх хэл, цаашид сурагчдынхаа суралцах бусад гадаад хэлний сургалтыг чухалчлан үзнэ². (АйБи Standard A, Practice 7).
- Хамтран төлөвлөж, харилцан ярилцаж хэвшсэнээр, бүх хичээл заадаг багш нар сурагч нэг бүрийнхээ хэл яриаг хөгжүүлэх үүрэг хүлээнэ³. (АйБи Standard C1, Practice 8).
- Хэл заах, сурах үйл явцыг сурагчдын хэлний мэдлэгийн хэрэгцээтэй нь, үүний дотор сурагчдын төрөлх хэлнээс бусад гадаад хэл сурах шаардлага хэрэгцээтэй нь уялдуулна (АйБи Standard C3, Practice 7).
- Бүх багш нар сурагчдын хэл яриаг хөгжүүлэх үүргээ биелүүлж буй эсэх нь хэл заах, сурах үйл явцаас харагдана (АйБи Standard C3, Practice 8).
- Кембридж хөтөлбөрийн хэлний бодлого дахь боловсролд хэлийг хэрхэн хэрэглэх талаарх 8 зарчим, хос хэл дээр сургалтыг хэрхэн явуулах талаар зарчим зэрэгт тулгуурласан⁴.

Олон улсын байгууллагуудтай англи хэлээр харилцдагаас гадна, сургуулийн дотоод дүрэм журам, мэдээллийг монгол, англи хэл дээр боловсруулж өөрийн цахим хуудсандаа байршуулдаг. Мөн сурагчдынхаа ажлыг англи, монгол хос

¹Cambridge principles into practice: Languages in your school: guidance for school leaders and teachers. Cambridge Assessment International Education. 2021. page 9

²Practical guide to languages for the Cambridge schools. Cambridge Assessment International Education. 2021. page 2-3

³Ibid

⁴"Teaching Bilingual Learners." *Cambridge Assessment International Education*, Cambridge, <https://www.cambridgeinternational.org/support-and-training-for-schools/professional-development/professional-development-qualifications/curriculum/teaching-bilingual-learners/>.

хэлээр тайлагнадгаас гадна сургуулийн мэдээллийн самбаруудыг англи, монгол хэл дээр гаргадаг.

СУДЛАХ ХЭЛ

Анги	Нас	Монгол хэл /7 хоногт/	Монгол бичиг /7 хоногт/	Англи хэл /7 хоногт/	Сонгон судлах цаг /7 хоногт/	Орос хэл /7 хоногт/	Франц хэл /7 хоногт/	Хятад хэл /7 хоногт/
I	6	7 цаг		4 цаг	-	-	-	-
II-V	6-11	6 цаг		5 цаг	-	-	-	-
VI-IX	12-14	VI ангид 7 цаг VII-IX ангид 6 цаг	2 цаг	6 цаг	-	VII-VIII ангид 2 цаг IX ангид 3 цаг	IX ангид 4 цаг	IX ангид 4 цаг
X	15	4 цаг	-	6 цаг	1 цаг	-	-	4 цаг
XI	16	4 цаг	-	6 цаг	2 цаг	-	-	6 цаг
XII	17	4 цаг	-	6 цаг	4 цаг	-	-	-

Төрөлх хэл:

"Шинэ Үе" сургуулийн сурагчдын 99,5 хувь нь төрөлх монгол хэлтэн бөгөөд 0,5 хувь нь Хятад, Солонгос, Япон, Америк сурагчид байна. Хэрэв сурагчийн төрөлх хэл нь монгол хэл биш бол тухайн сурагчийн төрөлх хэлний сургалтыг дэмжих үүднээс сургууль нь эцэг, эх, асран хамгаалагч, сурагчдын хүсэлтээр сурагчийн төрөлх хэлний мэдлэгийг дээшлүүлэхийн тулд гэрийн багш олох хэлбэрээр тусална. (Онлайн сургалт болон гэрийн багшийн зардал сургалтын төлбөрт багтахгүй болно).

Монгол хэл:

Монгол хэл нь сургалтын үндсэн, харилцааны хэл мөн. Сургуульд элсэн ороход сурагч бүр монгол хэлний шалгалт өгнө. (Манай элсэлтийн журмыг <http://shineue.edu.mn/form> -аас үзнэ үү.)

Хилийн чанадаас шилжин ирэх сурагчдын монгол хэлний түвшинг тогтоон, тэдний монгол хэлний мэдлэг, чадварыг дээшлүүлэх үүднээс хичээлээс гадуур нэмэлт сургалтад хамруулна.

Монгол хэлний багш нар хичээлийн жилийн улирал бүрийн эхэнд өөрсдийн давтлагын цаг болон хичээлийн төлөвлөгөөг гарган сургалтын менежерээр батлуулна.

АйБи дипломын хөтөлбөрийн Монгол суралцагчдын хувьд Mongolian A буюу уран зохиолын хичээлийг сонгон судлахыг зөвлөдөг.

Англи хэл:

Манай сургууль англи хэлийг сурагчдадаа нэгдүгээр ангиас эхлэн ахлах ангиа төгсгөл нь заадаг хоёрдогч хэл юм. Үүнд:

- **Бага анги:** Бага ангийн 1-р ангиас англи хэлний хичээлийг, 3-р ангиас байгалийн ухааны хичээлийг гадаад болон хос хэлтэн багш нар заадаг.
- **Дунд, ахлах анги:** Англи хэл нь 9-12 дугаар ангийн түүх, бизнес судлал, дэлхий нийтийн хэтийн төлөв (Global perspectives), байгалийн ухаан (General science) болон англи хэлний хичээлүүдийг заах үндсэн хэл бөгөөд АйБи дипломын хөтөлбөрийн Mongolian A буюу уран зохиол хичээлээс бусад бүх хичээлийг заах үндсэн хэл юм.

Англи хэлний багш нар хичээлийн жилийн улирал бүрийн эхэнд хичээлээс гадуур ажиллах давтлагын цагийн хуваарийг сургалтын менежертэй ярилцан зохицуулна. Одоо суралцаж буй сурагчдаас англи хэлээр хоцрогдолтой байгаа сурагчид болон тус сургуульд шилжин ирж буй сурагчдын англи хэлний түвшинг англи хэл дээр судалдаг бусад хичээлийг ойлгохуйц хэмжээнд хүргэнэ. Үүний тулд долоо хоногт 1-3 удаа хичээлээс гадуурх англи хэлний нэмэлт сургалтад хамруулж, 1-5 дугаар ангийн сурагчдыг А1-А2 түвшинд, 6-9-р ангийн сурагчдыг А2-В1 түвшинд, 10-12-р ангийн сурагчдыг В1-С1 түвшинд хүргэн хоцрогдлыг арилгадаг.

Мөн байгаль шинжлэлийн клуб, мэтгэлцээний клуб, уншлагын дугуйлангийн харилцааны гол хэл нь англи хэл юм.

Орос хэл:

Сургалтын төлөвлөгөөний дагуу 7-9 дүгээр ангийн сурагчдад анхан шатны орос хэлний хичээл заах журамтай. Энэхүү шаардлагыг биелүүлэх болон олон хэлний сургалтын үзэл санааг дэмжих үүднээс манай сургуульд орос хэлний хичээлийг унаган орос хэлтэй багш заадаг.

Хятад хэл:

Сурагчид 9 дүгээр ангиасаа Хятад болон Франц хэлнээс сонгон долоо хоногт 4 цагаар судалдаг. Мөн АйБи дипломын хөтөлбөрийн гадаад хэл эзэмшилт буюу 2-р бүлэгт хятад хэлийг сонгон судалдаг.

Хэл соёлыг сурталчлах:

Сургуулийн жилийн ажлын төлөвлөгөөнд улс орнуудын хэл, соёлыг сурталчлах өдрийг оруулж, зохион байгуулдаг.

СУРАГЧДЫН АХИЦЫГ ХЯНАХ, ЭЦЭГ ЭХ, АСРАН ХАМГААЛАГЧДАД МЭДЭЭЛЭХ

Хичээлээс гадуурх хэлний нэмэлт сургалт нь хамгийн багадаа хичээлийн 60 цагаас (хичээлийн 1 цаг 40 минут байна) бүрдэнэ. Сургалт эхлэхийн өмнө сурагчийн хэлний түвшинг бичгийн болон аман шалгалтаар тогтоож, хүрэх гэж буй түвшин хүртэл эцэг эх, асран хамгаалагчтай нэмэлт сургалтын гэрээ хийнэ. Гэрээнд хоцрогдол арилгах сургалтын төлөвлөгөө болон хуваарийг хавсаргана.

Хэлний хоцрогдол арилгах болон нэмэлт сургалтаар сурагчдад гарч буй сурлагын ахиц өөрчлөлтийг улирал бүрийн төгсгөлд түвшин тогтоох шалгалт авч үнэлгээг сурагч, эцэг эх, асран хамгаалагч, анги удирдсан багшид имэйлээр илгээж, хамтран ажиллана.

ХЭЛ ЗААХ БОЛОН СУРАХ АРГА ЗҮЙ

Манай сургууль нь хэлний 4 айг зэрэг хөгжүүлэх аргаар заадаг. Унших, бичих, ярих, сонсох болон хэлний хэрэглээ гэсэн чадамжуудаар хүрэх үр дүнг хичээл бүрээр тодорхойлсон. Тус сургуулийн тэнхимийн эрхлэгч болон сургалтын менежерүүд эдгээр чадамжууд нь өнөө үеийн боловсролын шаардлага хэрэгцээг хангаж чадаж байгаа эсэхэд хяналт тавин, шаардлагатай үед шинэчлэн боловсруулдаг.

ДЭМЖЛЭГ

Багшийн зүгээс үзүүлэх дэмжлэг:

- Хэл сурах орчныг бүрдүүлж, долоо хоногт/улиралд тухайн заасан хичээлийн аль нэг бүлэг/сэдэвт холбогдох мэргэжлийн гол үг хэллэг, нэр томъёонуудыг түүвэрлээд, утга агуулгыг нь тайлбарлах, жагсаан бичүүлэх/самбарт тавьдаг.
- Багш нар сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрт заасны дагуу арга зүй, хэрэглэгдэхүүнээ хэлний түвшинд тохируулан сонгодог.

- Мэргэжлийн багш нар гарын авлага бичих, орчуулах, олимпиад, уралдаан тэмцээнд бэлтгэх, сургалт зохион байгуулах зэрэг ажилд гадаад хэлний багш нартай хамтран ажилладаг.
- Нэг сэдэв агуулгын хүрээнд өмнөх мэдлэг ойлголтод суурилсан төрөл бүрийн үйл ажиллагаа явуулснаар аль нэг сэдвийн талаар өөрийгөө илэрхийлэх чадварыг хөгжүүлдэг.
- Үгсийн санг бүтээлчээр хэрэглэж, сургахад голлон анхаарч, бичих дадлага эзэмшүүлэх дасгалыг долоо хоног/сар тутам тогтмол хийлгэх, бичгийн чадварыг нэмэгдүүлэх боломж олгох үүднээс тухайн зохион бичлэгүүдийг анги бүлгээрээ хамтран хянан засварладаг.
- Уншиж ойлгох чадварыг нэмэгдүүлэх үүднээс график, хүснэгт, зурагт үзүүлэн бэлдэх үйл ажиллагаа явуулах, ном сэтгүүл уншиж ашиглах, дадлага суулгахад голлон анхаарч, уншлагын дасгал сургалтыг долоо хоног/сар тутам зохиодог.

Сургуулиас үзүүлэх дэмжлэг:

Сурагчдад олон хэл дээр унших боломж олгох үүднээс хэлний багш нар болон номын санч шаардлагатай ном зохиолыг танилцуулж зөвлөх үүрэгтэй.

Сурагчид манай сургуулийн номын санд байгаа төрөл бүрийн толь бичиг, сонин сэтгүүлийг ашиглах боломжтойгоос гадна захиалж болно.

Сурагчдад хэл сурах нэмэлт боломж олгох үүднээс хичээлийн бус цагаар тус сургуулийн компьютерын лабораторид сууж ажиллан хэл сурах төрөл бүрийн программыг нээж ашиглахыг зөвшөөрдөг.

Гадаад хэлний болон олон улсын хөтөлбөрийн багш нарын хувьд <https://www.twinkl.com/> болон <https://www.thinkib.net/> сайтаас багш нар хэрэгцээтэй материалаа авч баяжуулан ашигладаг.

Сургуулийн зөвлөх нь төгсөх ангийн сурагчдад мэргэжлийн чиг баримжаа олгох асуудалд англи хэлний болон бусад мэргэжлийн багш нартай хамтран ажилладаг.

Багш нарт үзүүлэх дэмжлэг:

Шинэ Үе сургуулийн олон улсын хөтөлбөрийн багш нар англи хэлний A1-B2 түвшинтэй бөгөөд англи хэл дээр сургалтын хөтөлбөрөө бэлтгэхэд төвөггүй байдаг.

Сургуулиас мэргэжлийн багш нарын англи хэлний мэдлэгийг сайжруулах зорилгоор хичээлийн жилийн эхэнд багш, ажилтны хэлний чадварын түвшинг тогтоож, түвшин бүрд тохирсон сургалтыг тусгай багш томилон ажиллуулдаг. Ингэснээр багш нарын

мэргэжлийн, заах аргын болон харилцааны англи хэлний чадварууд сайжирдаг/subject specific, pedagogical, social language./

Гадаад хэлний багш нарт TOEIC/IELTS/TOEFL-ийн шалгалтад бэлдэх болон бусад заах арга зүйн сургалтыг гадаад багш нартай хамтран зохион байгуулдаг.

Гадаад хэлнээс бусад мэргэжлийн багш нар мэргэжлийн ном, гарын авлага, товхимлуудыг англи хэлээр судлан нэгж болон ээлжит хичээлээ бэлддэг.

ЖУРМЫГ ХЯНАН ӨӨРЧЛӨХ ЯВЦ

Журамд өөрчлөлт оруулах асуудлыг багш нарын 70-аас доошгүй хувийн ирцтэй хурлаар хэлэлцэн батална.

Ашигласан материалын жагсаалт

1. International Baccalaureate Organization (2017). DP Grade Descriptors. Retrieved April 8, 2021.
2. International Baccalaureate Organization (2015). DP: From principles into practice. Retrieved April 8, 2021.
3. International Baccalaureate Organization (2018). Diploma Programme Assessment Procedures. Retrieved April 8, 2021.
4. International Baccalaureate Organization (2010). Guidelines for developing a school assessment policy in the Diploma Programme. Retrieved April 8, 2021.
5. SUS АйБиDP Handbook 2021-2023. Retrieved May 5, 2021.
6. Cambridge. (n.d.). *Cambridge principles into practice - languages guide for Schools*. Cambridge Assessment International Education. Retrieved December 14, 2021, from <https://www.cambridgeinternational.org/support-and-training-for-schools/teaching-cambridge-at-your-school/cambridge-principles-into-practice-languages-guide-for-schools/>
7. “Teaching Bilingual Learners.” *Cambridge Assessment International Education*, Cambridge, <https://www.cambridgeinternational.org/support-and-training-for-schools/professional-development/professional-development-qualifications/curriculum/teaching-bilingual-learners/>.
8. “Teaching Cambridge at Your School.” *Cambridge Assessment International Education*, Cambridge, <https://www.cambridgeinternational.org/support-and-training-for-schools/teaching-cambridge-at-your-school/>.



Шинэ Үе сургуулийн
Хэлний Журам



Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, ЮНЕСКО гудамж 12
Улаанбаатар, Монгол улс